

**СҮМБЭР СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ
 \ 2019 оны жилийн эцсийн байдлаар **

2019-12-12

№	Дунд хугацааны зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Шаардагд ах хөрөнгө, эх үүсвэр /сая.төг	Хүрсэн үр дүн, хэрэгжилт	Хэрэгжилт ийн хувь	
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН БОДЛОГО								
Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хэмнэлтийг эрхэмлэн, орон нутгийн нөөцөд суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.								
1	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	1.1.1 Төсвийн үр ашиггүй зардлыг хэмнэх бодлого баримтлана.	Холбоотой зөрчил гараагүй байна.	100хувь		Сумын харьяа төсвийн байгууллагуудаас санхүүгийн зөрчил гараагүй. Засгийн газрын 147 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.11 дүгээр сарын байдлаар орон нутгийн болон тусгай зориулалтын авлага 28565.4 мянган төгрөг, өглөг нь 126955.1 мянган төгрөг болсон байна. Өр авлага үүсгэхгүй байх, үүссэн өр авлагаа тайлант хугацаанд барагдуулах талаар хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	100	
2		1.1.2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд тавих иргэдийн хяналтыг чангатгана.	ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын санал авахад оролцсон нийт өрхийн эзлэх хувь Хийсэн ажлын чанар	100 хувь		Сангийн сайдын 288-р журмын дагуу Сумын 2020 оны ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг сумын нийт өрхийн 70 хувиас цаасан саналын хуудсаар авсан байна. 05 дугаар сард багуудын ИНХ-аар 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг эрэмбэлүүлж, ЗДТГ-т хүргүүлсэн. Сумын ОНХСангийн шилэн дансны цахим хуудсанд 13 нэр төрлийн мэдээ мэдээллийг цаг тухай бүр нийтэлж байна. Төсөвт байгууллагуудын холбогдох албан хаагчид сар бүрийн мэдээллээ тогтмол https://shilendans.gov.mn шилэн дансны вэб сайтад хугацаанд нь байршуулсан. Сумын Засаг даргын Тамгын газар, Сум хөгжүүлэх сан, ОНХСангийн мэдээлэл болон тушаал захирамжийг тухай бүрт нь PDF болгон оруулсан	100	
3	1.2	Бизнесийн	1.2.1.Иргэдийн үйлдвэрлэл,	5 хувиар ажлын	100 хувь	СХС,	Аймгийн ЖДҮД санд 5 иргэн 455,6 сая	100

		таатай орчин бүрдүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.	үйлчилгээ, хөнгөн болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах иргэдийн үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжинэ.	байрыг нэмэгдүүлнэ		ЖДҮДС	төгрөгний санхүүжилттэй төсөл өгснөөс 2 иргэний 185,6 сая төгрөгний төсөл санхүүжилт авсан.	
4			1.2.2.Сум хөгжүүлэх сангийн зээлийг сумын эдийн засгийн бодлоготой уялдуулан, иргэдийн оролцоо, хяналттайгаар олгож, үр ашгийг нь нэмэгдүүлнэ.	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, төлөлтийг жигдрүүлнэ.	Эргэн төлөлтөөр 209,8 мянган төгрөг төвлөрүүлнэ.	СХС, ЖДҮДС	2019 онд “Сум хөгжүүлэх сангийн зээлийг нөхөн төлүүлэх” 2 сарын аяныг зохион байгуулан ажиллалаа. Энэ ажлын хүрээнд зээлийн эргэн төлөлтийг хугацаандаа төлж барагдуулаагүй 3 иргэний материалыг аймгийн Прокурорын газарт, 4 иргэний материалыг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. Шүүхээс тодорхой хугацаа өгсөн боловч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй 4 зээлдэгчийн материалыг ШШГГазартай гэрээ байгуулан шилжүүлсэн. ШШГГазарт материалыг нь өгсөн 2 зээлдэгч 12700000 төгрөгний зээлээ бүрэн төлж барагдуулсан. Тус санд 11 сарын 30-ны байдлаар 192363901 төгрөг төвлөрүүлэхээс 157216149 сая төгрөг төвлөрүүлж зээлийн эргэн төлөлт 81,7 хувьтай байна Сум хөгжүүлэх сангаас Хөдөө аж ахуй чиглэлээр-3 иргэнд 48,0 сая төгрөг, автотасварын чиглэлээр 2 иргэд 40,0 сая төгрөг, хүнсний чиглэлээр-3 иргэд 55,0 сая төгрөг, хоёрдогч түүхий эд ангилах ялгах чиглэлээр 1 иргэд 10,0 сая төгрөг нийт 9 иргэнд 153,0 сая төгрөгний санхүүжилт олгогд байна	100
5			1.2.3 Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн хоршооны үйл ажиллагааг дэмжиж, мэргэжил арга зүйгээр ханган дундын хоршоо байгуулна.	Хоршоологчдын үйл ажиллагаа сайжирна.		ЖДҮДС	Газар тариалан болон мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 хоршоо нэгдэн “Боржигон төв импекс” дундын хоршоо байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Хоршооны үйл ажиллагааг дэмжиж эрчимжсэн мал аж ахуйн бүсэд “мал нядалгааны цех” байгуулах зориулалтаар газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн	100
Зорилт 1-ийн хэрэгжилт		Дүгнэлт: Хэрэгжсэн хувь 100						
ХОЁР.ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО								
Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.								
6	2.1	Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр угсааг сайжруулж	2.1.1.Малыг индексжүүлсэн даатгалд хамруулж, эрсдлээс хамгаална.	Даатгалд хамрагдсан малын эзлэх хувь	Өмнөх оныхоос Урд оноос 5 хувиар өсгөнө.	ОНТ	Малын индексжүүлсэн даатгалын талаархи мэдээллийг багуудын өдөрлөг болон малчдын гэрээр орж сурталчилгаа хийж гарын авлага тараасан. Малын индексжүүлсэн даатгалд	100

		ашиг шимийг дээшлүүлнэ.					даатгуулах ажил 04 сарын 01-ээс 06 дугаар сарын 30-ны хооронд явагдсан. Малын индексжүүлсэн даатгалд 81 өрхийн 27123 толгой малыг даатгуулсан нь нийт малчин өрхийн 14,6% болж байна. Өмнөх оноос 7,4%-аар өссөн үзүүлэлтэй байна.	
7		2.1.2. Мал сүргийг ээмэгжүүлэн цахим бүртгэлд оруулж, мэдээллийн санг нэмэгдүүлнэ.	Нийт малын 8 хувийг ээмэглэж, цахим санд бүртгэнэ.	Хээлтүүлэгч малын 100 хувь, хээлтэгч малын 20 хувь, үхрийг 100 хувь ээмэглэж цахим санд бүртгэнэ.	ОНТ	Мал сүргийг ээмэгжүүлэн цахим бүртгэлд оруулж, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулан хээлтүүлэгч малыг 100 хувь, хээлтэгч малын 1.3 хувийг ээмэглэж цахим санд бүртгэсэн. Цахим санд бүртгэх, мэдээлийг нэгдсэн санд дамжуулах ажил хийгдэж байна. 1470 эм хонь, 850 эм ямаа, 123 бух,805 хуц, 675 ухнанд ангилалт хийсэн.	100	
8		2.1.3 Мал хамгаалах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Хөтөлбөр биелэгдсэн байна.	100 хувь	ОНХС	Сумын “Мал хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд 2019 онд 12 зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан.	100	
9		2.1.4 Цөөн малтай 10 өрхийг малжуулна.	Гүйцэтгэлээр	100 хувь	ОНХС	Сумын малжуулах төслийн хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 23-аас 25-ны өдрүүдэд цөөн малтай, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 10 өрхийг малжуулсан.	100	
10		2.1.5. Бэлчээрийг ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	Бэлчээр сайжирсан байна.	100 хувь	ОНХС	Бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор малчдын дунд бэлчээр хамгаалах бүлэг байгуулаад байна. 8 дугаар сард бэлчээрийг зөв зохистой ашиглах, бэлчээрийн даацыг тодорхойлох, бэлчээр сэлгэн нүүхийн ач холбогдолын талаар сургалт зөвлөгөөн зохион байгуулаа.	70	
11		2.1.6.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	100 хувь	ОНТ	Сумын ХАА, МЭҮТ-аас “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд Малчдын зөвлөгөөн, хөдөөгийн багийн өдөрлөг, малын индексжүүлсэн даатгал, Арьс ширний урамшуулал, мал эмнэлгийн үржлийн ажил үйлчилгээг үзүүлэх явц болон өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд давхардсан тоогоор 578 малчдад мэдээлэл хүргэж, зөвлөгөө, арга зүй өгч ажилласан.	100	
12		2.1.7 Бэлчээр хамгаалах малчдын бүлэг байгуулан бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээхэд малчдыг татан оролцуулна.	Бэлчээр хамгаалах малчдын бүлгийг сургалтанд хамруулж чадавхижуулна.	100 хувь	ОНХС Төсөл хөтөлбөр ХХО	Бэлчээрийг ашиглах, хамгаалах зорилгоор хөдөөгийн багууд айл өрхөө суурьшлын байдлаар бүлэг болгон ажиллаж байна . Энэ нь өөрсдийн бэлчээрийг хашиж хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх ажлуудыг зохион байгуулахад ач холбогдол өгч байна.	100	

13			2.1.8 Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан огтоно, хөнөөлт шавьжийн тоо толгой, тархалт, байршлийг тогтоож тэмцэнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 удаа 1-рт судалгаа хийгдэнэ. 2-рт тэмцэл хийсэн тоо	6 мя- га-д угсгал хийгдсэн байна.	УТХО	Хавар 5,6-р багийн 300 га талбайд 25 хүний бүрэлдэхүүнтэй, 11 дүгээр сард ХХААХҮЯамны санхүүжилтээр 5,6-р багийн бэлчээр нутагт 18,0 га талбайд хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг малчдын оролцоотойгоор зохион байгуулсан Сүмбэр айраг хоршоо 10 га талбайд олон наст тэжээлийн ургамал тариалж 50тн ургац хураан авсан	100
14			2.1.9 Сумын бэлчээрийн даацийг тодорхойлох ажлыг хавар намрын улиралд зохион байгуулна.	2 удаа	100 хувь	ОНХС	Бэлчээрийн даацыг 2 удаа тогтоосон. Хавар 4,5,6 дугаар багийн бэлчээр ашиглалтын 13 хэсгийн 3240229,74 га бэлчээрийн талбайн 26 мониторингийн цэгүүдэд хээрийн судалгааг хийсэн. Бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн гэсэн тооцоо гарсан. Намрын судалгаагаар 100 га талбайд ойролцоогоор хонин толгойд шилжүүлснээр 103 толгой мал бэлчээрлэх боломжтой гэж тогтоогдсон.	100
15	2.2	Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2.2.1. Эрчимсэн мал аж ахуйг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэхийг тэргүүлэх чиглэлээ болгоно.	Бүтээгдэхүүний тоо өссөн байна		СХС ОНТ	Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийн газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн. Гахай, тахианы аж ахуй эрхлэх зорилгоор 2 иргэн ЖДҮ-ийг дэмжих сангаас зээлийн дэмжлэг авахаар санал ирүүлснийг холбогдох газар хүргүүлсэн.Мөн сум хөгжүүлэх сангаас 1 иргэд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 10,0 сая төгрөгний санхүүжилт олгоод байна	70
16	2.3	Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ.	2.3.1 Малын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлогын хэрэгжилтийг орон нутагтаа оновчтой зохион байгуулах, гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг хуулийн хугацаанд чанартай шуурхай зохион байгуулна.	Вакцинжуулалтанд хамрагдах малын тоо	100 хувь	ОНТ	Мал эмнэлэгийн 7 нэгжтэй гэрээ байгуулан, үйл ажиллагааг нь дэмжиж байнгын холбоотой ажиллаж байна. МЭГ-аас 3 нэр төрлийн халдварт өвчнөөс хамгаалах био тарилга хүлээн авч, вакцинжуулалтыг технологит хугацаанд нь зохион байгуулав. Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 16.2 мян.толгой мал, амьтан хамруулахаас 16.928 мян.толгой мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 100 %. Энэ жил ямын харшил сорилын шинжилгээнд 1.4 мян.толгой адуу хамруулахаас 1.391 мян.толгой адуу хамруулж, гүйцэтгэл 100%. Өвчлөл илрээгүй. Үхрийн сүрьеэгийн шинжилгээнд 1.4 мян.тол үхэр хамруулахаас 1.39 мян.тол үхэр хамруулж, гүйцэтгэл 100%. Сүрьеэгийн өвчлөл илрээгүй. Ажил үйлчилгээний хөлсөнд орон нутгийн төсвөөс 5711600 төгрөг олгов. Халдварт	100

						<p>өвчнөөр тайван байна.</p> <p>Бруцеллёзоос эрүүлжүүлэх стратеги төлөвлөгөө"-ний хүрээнд 57.068 мян.тун вакцин хүлээн авч 106.5 мян.тол охин тугал, хурга, ишиг вакцинжуулахаас 56.770 мян.тол төл мал вакцинжуулж, гүйцэтгэл 100 %. Ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 8571000 төгрөг олгов.</p> <p>Зооноз өвчнөөс хамгаалах 2 нэр төрлийн био тарилга хүлээн авч вакцинжуулалтыг технологит хугацаанд нь зохион байгуулав. Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 5.7 мян.тол мал, амьтан хамруулахаас 5.963 мян.тол мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 100 %. Ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 1006000 төгрөг нэхэмжилээд байна.</p> <p>Гоц халдварт шүлхийгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх мэдрэмтгий малыг хаврын вакцинжуулах ажлыг 6 дугаар сараас эхлэн 2 үе шаттайгаар зохион байгуулж 11 дүгээр сарын 29-ны өдөр дууслаа. Зуны вакцинжуулалтанд 334.8 мян.тол мал хамруулахаар төлөвлөснөөс 312.238 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 93 % хамруулж, ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 47273850 төгрөг олгов. Намрын вакцинжуулалтанд 11.752 мян/тол малыг 100% хамруулав.</p> <p>Гоц халдварт хонины цэцэг өвчинөөс урьдчилан сэргийлэх хэмжээний хүрээнд Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх мэдрэмтгий хониныг вакцинжуулах ажлыг 09 дүгээр сарын 09-өөс эхлэн зохион байгуулж 09 дүгээр сарын 28-ны өдөр дууслаа. Вакцинжуулалтанд 52.2 мян.тол мал хамруулахаар төлөвлөснөөс 51.684 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 100 % хамруулж, ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 7752600 төгрөг олгов.</p> <p>Гоц халдварт бог малын мялзан өвчөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2018 оны үлдэгдэл 60.3 мян.тун вакциныг Сүмбэр сумын 6 багийн нутаг дэвсгэр дэх мэдрэмтгий бог малыг 08 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн 2 үе шаттайгаар зохион байгуулж 11 дүгээр сарын 29-ны өдөр дууслаа.</p>
--	--	--	--	--	--	---

							<p>Зуны вакцинжуулалтанд 60.3 мян.тол бог мал хамруулахаар төлөвлөснөөс 60.094 мян.тол бог мал хамруулж, гүйцэтгэл 100 % хамруулж, ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 9014100 төгрөг нэхэмжилсэн. Намрын вакцинжуулалтанд 90.0 мян/тол бог малыг хамруулхаас 89.552 мян/тол бог малыг 100% хамруулж, ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 13432800 төгрөг нэхэмжилсэн. Нийт 22446900 төгрөг олгоно.</p> <p>Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 207.34 мян.тол мал хамруулахаас 242.315 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 100 %. Угаалганд 120.525 мян.тол, боловсруулалтанд 72.27 мян.тол, туулгалтанд 49.4 мян.тол мал хамрууллаа. Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний эмийн үнэ, үйлчилгээний хөлсийг малчид хариуцдаг тул ивOMEкийг худалдан авч өөрсдөө тарих байдал газар авч байна. Паразиттах өвчнөөр тайван байна.</p> <p>МЭАЦ-ийн ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээнд МАА-н гаралтай 52.1 мян.м² талбай хамруулахаас 159 цэгийн 36.425 мян.м² талбай хамруулж, гүйцэтгэл 70 %. –тай байна.</p>	
17	2.4	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2.4.1 Өрх, иргэдийг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж өөрсдийн хэрэгцээг хангах санаачлагыг дэмжиж, арга зүйгээр хангаж ажиллана.	Өмнөх оноос 10% өссөн үзүүлэлттэй байна.	100 хувь	ОНТ ХХО	<p>Хавар Аймгийн ХХААГазартай хамтран тариалан эрхлэгчдийн дунд “Төмс хүнсний ногоо тариалах технологи”-ийн чиглэлээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтанд газар тариалан эрхлэх хүсэлтэй 15 иргэн хамрагдсан. Сумын хэмжээнд төмс-108.3 тн, хүнсний ногоо 110.1 тн, малын тэжээл 50 тн нийт 268.4 тн төмс, хүнсний ногоо, малын тэжээл хураан аваад байна. Энэ нь өмнөх оноос 134,88 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна Нэгж ургацын хэмжээ 75-80ц/га байна</p>	100

							<table border="1"> <thead> <tr> <th>Төрөл</th> <th>2018</th> <th>2019</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ТӨМС</td> <td>65.07</td> <td>108.31</td> </tr> <tr> <td>ХҮНСНИЙ НОГОО</td> <td>63.46</td> <td>110.1</td> </tr> <tr> <td>МАЛЫН ТЭЖЭЭЛ</td> <td>5</td> <td>50</td> </tr> <tr> <td>НИЙТ</td> <td>133.53</td> <td>268.41</td> </tr> </tbody> </table>	Төрөл	2018	2019	ТӨМС	65.07	108.31	ХҮНСНИЙ НОГОО	63.46	110.1	МАЛЫН ТЭЖЭЭЛ	5	50	НИЙТ	133.53	268.41	
Төрөл	2018	2019																					
ТӨМС	65.07	108.31																					
ХҮНСНИЙ НОГОО	63.46	110.1																					
МАЛЫН ТЭЖЭЭЛ	5	50																					
НИЙТ	133.53	268.41																					
18	2.5	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2.5.1.“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”, “Сум хөгжүүлэх сан” гаас зээл олгох замаар орон нутагтаа үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ажлын байрыг бий болгоно.	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. ЖДҮДС, СХСангийн зээлийн эргэн төлөлт, ашиглалтыг сайжруулна.	Бий болсон ажлын байрны тоо Эргэн төлөлтөөр	ЖДҮДС СХС	<p>2019 онд “Сум хөгжүүлэх сангийн зээлийг нөхөн төлүүлэх” 2 сарын аяныг зохион байгуулан ажиллалаа. Энэ ажлын хүрээнд зээлийн эргэн төлөлтийг хугацаандаа төлж барагдуулаагүй 3 иргэний материалыг аймгийн Прокурорын газарт, 4 иргэний материалыг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. Шүүхээс тодорхой хугацаа өгсөн боловч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй 4 зээлдэгчийн материалыг ШШГГазартай гэрээ байгуулан шилжүүлсэн. ШШГГазарт материалыг нь өгсөн 2 зээлдэгч 12700000 төгрөгний зээлээ бүрэн төлж барагдуулсан. Тус санд 11 сарын 30-ны байдлаар 192363901 төгрөг төвлөрүүлэхээс 157216149 сая төгрөг төвлөрүүлж зээлийн эргэн төлөлт 81,7 хувьтай байна</p> <p>Сум хөгжүүлэх сангаас Хөдөө аж ахуйн чиглэлээр-3 иргэнд 48,0 сая төгрөг, автотасварын чиглэлээр 2 иргэнд 40,0 сая төгрөг, хүнсний чиглэлээр-3 иргэнд 55,0 сая төгрөг, хоёрдогч түүхий эд ангилах ялгах чиглэлээр 1 иргэнд 10,0 сая төгрөг нийт 9 иргэнд 153,0 сая төгрөгний санхүүжилт олгоод байна.</p> <p>Аймгийн ЖДҮДСангаас /арьсан эдлэлийн чиглэлээр-1, модон эдлэлийн чиглэлээр-2, гэрэл зураг хэвлэлийн чиглэлээр-1, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр-2, цаасан хайрцаг сав баглаа боодлын чиглэлээр-1, гутал засвар үйлчилгээний чиглэлээр-1 иргэн/ нийт 8 иргэнд 415,0 сая төгрөгний санхүүжилт олгож , 28 ажлын байр бий болгоод байна</p>	100															

19	2.6	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангана.	2.6.1 Хүн амаа аюулгүй эрүүл хүнсээр хангах бодлого баримтлаж, тавих хяналтыг чангатгана.	Иргэд эрүүл хүнсээр хангагдана.	Үйл ажиллагаа жигдэрнэ.	ОНТ	Аймгийн МЭГ-н эмч нар болон “Чойр таван эрдэнэ” МЭҮ-н нэгжтэй хамтран малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдаа эрхлэгч иргэд аж ахуй нэгжүүдэд сүү, махны гарал үүсэл, эрүүл ахуйн байдалд 4 удаа хяналт тавьж Балдан засаг, Өгөөж хүнсний зах дээр сүү, махны худалдаа эрхлэгч 28 иргэний мах махан бүтээгдэхүүнийг МЭАЦ-н лабораторийн шинжилгээнд хамруулж зөвлөмж өгсөн. Хүрээлэн байгаа орчны эсрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг байгаль орчны болон мал эмнэлгийн улсын хяналтын байцаагч нартай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал амьтны гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүн худалдаалдаг аж ахуй нэгж иргэд, авто тээврийн болон такси үйлчилгээ зэрэг нийт 36 газарт хяналт тавьж хууль бус амьтны мах хэрэглэх, худалдан авахгүй, тээвэрлэхгүй байх тухай зөвлөмж өгч зоонозын халдварт өвчний тухай сэрэмжлүүлэг, гарын авлага, боршурыг 118 ш, Цагдаагийн авто тээврийн шалган нэвтрүүлэх хяналтын постоор 96 автомашин тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг явуулсан.	70
20	2.7	Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр	2.7.1 Хуулийн шаардлага хангасан тусгай зөвшөөрлийг цаг алдалгүй шийдвэрлэнэ.	Хуулийн шаардлага хангасан аж ахуй нэгжүүдэд олгосон зөвшөөрөл			Сумын Засаг даргын захирамжаар тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг шинээр 5, сунгалтаар 4 иргэн, аж ахуй нэгжид олгосон. Тамхины тусгай зөвшөөрөл олголтын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэлтийн мэдээг сар болгон аймгийн татварын хэлтэст гаргаж өгч байна.	100
21			2.7.2 “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллана.	Иргэд эрүүл аюулгүй амьдрах нөхцөл бүрдэнэ.	Гүйцэтгэлээр	ОНХС	Суманд 7 худаг тогтмол ажиллаж гэр хороололын иргэдийн ундны усны хэрэгцээг хангаж байна. Улирал бүр усыг шинжилгээнд хамруулан, усны машин болон худгийн усны нөөцийн сав, ариутгалын ажлыг “ Сүмбэр 3	100

							бат" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Хуванцар савны хэрэглээг бууруулах тухай 166 ширхэг гарын авлага хэвлэн гаргаж тараасан ба уст цэгүүдийн мэдээллийн самбарт зөвлөмж байршуулан ажиллаж байна.	
Зорилт 2-ын хэрэгжилт			Дүгнэлт: Хэрэгжсэн хувь 94,4					
ГУРАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГО								
Сумын төвийн дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтийг сайжруулна.								
22	3.1	Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлнэ.	3.1.1. Иргэдийн өмчлөлийн газрын хэмжээг нэмэгдүүлнэ.	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	100 хувь	ОНТ	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу 100 иргэнд 7 га өмчлүүлэхээр шийдвэрлэгдсэний дагуу 6 дугаар сард газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамж 2019 оны 09-р сарын 26-нд гарсан.	100
23			3.1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийн ашиглалтад хяналт тавьж ажиллана.	Мэдээллийн сантай болсон байна.	100 хувь	ОНТ	2019 онд 7 ААНБайгууллага, 6 иргэнтэй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээ байгуулан 14,824,500 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, олборлолтонд хяналт тавьж байна. Ашигт малтмалын нөөцийг судлах, мэдээллийн сан бий болгох хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.	70
24			3.1.3 Нийтийн эзэмшлийн байрнуудын дээврийг үргэлжлүүлэн засварлана.	Засварласан байрны тоо	100 хувь	ОНХС	Нийтийн эзэмшлийн орон сууц, замчдын гудамж 1-101а, 101б, 101в, Тээвэрчдийн өргөн чөлөө 1-101а, 101б, 101в дугаар байрнуудын дээврийн их засварын ажлыг "Жи Ти Кэй Эс" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлж 3067м ² 6 байрны дээвэр засварлаж ашиглалтанд хүлээн авсан.	100
25			3.1.4 Ашигт малтмалын нөөцийн талаар судлан, мэдээллийн сан бүрдүүлж, хамгаалах, ашиглалт олборлолт явуулж буй газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, нөхөн сэргээлтийг тогтмол хийлгэнэ.	Ашигт малтмалын мэдээллийн сан бүрдүүлнэ	100 хувь	ОНТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, олборлолтонд хяналт тавин ажиллаж байна. Ашигт малтмалын нөөцийг судлах, мэдээллийн сан бий болгох хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.	70
26			3.1.5 Иргэд, газар ашиглагч, эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудын газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авна.	Газрын төлбөрийн хэмжээ нэмэгдэнэ.	Гүйцэтгэлээр		Сумын хэмжээнд иргэд, газар ашиглагч, эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудаас 93,653,035 төгрөгний газрын төлбөрийн орлого төвлөрүүлээд байна.	70
27			3.1.6.Өвөлжөө хаваржааны доорхи газрыг зурагт оруулж, сумын хэмжээнд тоон мэдээлэлд оруулна.	Гүйцэтгэлээр	100 хувь	ОНТ	Өвөлжөө хаваржааны зориулалтаар олгогдсон газар эзэмшигчдээс нийт 58 иргэний материалыг мэдээллийн санд оруулаад байна.	100

28	3.2		3.2.1 Газрын биржийн цахим системийг нэвтрүүлнэ.	Газрын биржийн цахим системээр газар өмчлөл, эзэмшил, төсөл, сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг зохион байгуулна.	100 хувь		Газрын биржийн 6 төрлийн цахим системийг ашиглаж байна. 2019 оны байдлаар: <ul style="list-style-type: none"> • Төсөл сонгон шалгаруулалт-2 • Дуудлага худалдаа-2 • Барьцаа-37 • Түрээс -1 <p>2019 онд газрын цахим биржийг ашиглан 2 байршилд 2 дуудлага худалдааг зохион байгуулсан.</p> <p>Сумын Засаг даргын захирамжаар 2 удаа төсөл сонгон шалгаруулалт зарлан зохион байгууллаа.</p>	100
29	3.3	Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна.	3.3.1 1 дүгээр багийн ТЗ-ын айл өрхийн бохирыг аймгийн төвийн нэгдсэн системд холбоно.	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО	1 дүгээр багийн бохирыг төв цэвэрлэх байгууламжид холбох ажлыг эхлүүлсэн.2019 оны ажлын санхүүжилтийг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар эхний ээлжинд санхүүжүүлэх ажлын жагсаалтад оруулсан боловч улсын төсвийн тодотгол хийгдээгүй тул хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй.	ҮБ
30			3.3.2 2 дугаар багийн айл өрхийг цэвэр усны шугаманд холбох ажлыг эхлүүлнэ.	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО	Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажлыг 3,2055 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Санжат ХХК-тай гэрээ байгуулсан. Цэвэр усны төв шугамын ажил 30%, усан сангийн ажил 70%-тай явагдаж байна.	70
31			3.3.3 Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайг засварлана.	Сумын төвийн өнгө үзэмж сайжирна.	100 хувь	Аймгийн ОНХС	“Цэргийн алдар хөшөө”-ний тохижилтын ажлыг аймгийн ОНХСангийн 180.0 сая төгрөгөөр “Топ универсаль” ХХК, 2019 оны 112,5 сая төгрөгөөр “Энх Энэрлийн Өргөө” ХХК-ууд гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
							Орон сууцны тоглоомын талбайн тохижилтын ажлыг Улсын төсвийн 499,0 сая төгрөгөөр “Си Эйч Си” ХХК гүйцэтгэж ажлыг улсын комисс хүлээж авсан.	
							Боржигон чуулгын өмнөх талбайг 100.0 төгрөгөөр “Арвайн толгой” ХХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан.	
							1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтыг Улсын төсвийн 249,9 сая төгрөгөөр “Осо констракшн” ХХК гүйцэтгэж, ашиглалтад	

						хүлээлгэн өгсөн.	
32		3.3.4 Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	Шинээр нэмэгдсэн гэрлийн тоо	100 хувь	УТХО	Улсын төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгөөр гэрэлтүүлгийн ажил гүйцэтгүүлэхээр “Осо констракшн” ХХК-тай 147 сая төгрөгөөр гэрээ байгуулж ажлын хэсэг хүлээж авсан.	100
33		3.3.5 Нийтийн эзэмшлийн 2 дугаар байрны подвалын шугамыг засварлана.			ОНХС	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр Нийтийн эзэмшлийн 2 дугаар байрны подвалын шугамыг засварлах ажлыг Ус-Ду ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан. Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комисс хүлээн авсан	100
34		3.3.6 Шинээр олгогдсон өмчлөлийн газарт цахилгаан татах ажлыг үе шаттайгаар хийнэ.			УТХО	Улсын төсвийн 357.5 сая төгрөгийн хөрөнгөөр Алтат, Хүхий, Цайдам, Гашуун, Тагтын эгнээнүүдэд 0.4 кВт-ын ЦДАШ татаж, 250 кВт КТПН байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Эрчим хүчний яаман дээр тендер зарлагдаж гэрээ байгуулахаар хүлээгдэж байна.	40
35		3.3.7.“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дэмжин техник тоног төхөөрөмж, ажиллах хүчээр бүрэн хангах бодлого барьж ажиллана.	Техник тоног төхөөрөмж засварлана.	100 хувь	ОНТ	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ газар нь батлагдсан төсвийн хүрээнд 32 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	70
36		3.3.8 “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын хог зөөврийн машины тоог нэмэгдүүлнэ.	Гүйцэтгэлээр	100 хувь	Аймгийн ОНХС	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ газарт хог үүрдэг авто машиныг Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авч өгсөн.	100
37		3.3.9 Сумын төвд өмчлөлд авсан газруудын цахилгаан хангамжийг үе шаттай шийдвэрлэнэ.	Гүйцэтгэлээр	100 хувь	УТХО	Улсын төсвийн 357.5 сая төгрөгийн хөрөнгөөр Алтат, Хүхий, Цайдам, Гашуун, Тагтын эгнээнүүдэд 0.4 кВт-ын ЦДАШ татаж, 250 кВт КТПН байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Эрчим хүчний яаман дээр тендер зарлагдаж гэрээ байгуулахаар хүлээгдэж байна.	40
38		3.3.10 Сүмбэр сумын 3 дугаар багийн 5,7,9 12 дугаар байрны орчимд авто зогсоол байгуулна.	2400 м.к	100 хувь	УТХО	3 дугаар багийн 7,9,12-р байрны орчимд авто зам, зогсоол байгуулах ажлыг “Борхойн зам” ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэн улсын комисс хүлээн авсан.	100
Зорилт 3-ын хэрэгжилт		Дүгнэлт: Хэрэгжсэн хувь 83,1					
ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГО							
Хүний хөгжлийг бүх талаар дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьжиргааг тогтвортой дээшлүүлж, иргэдийн боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
4.1 Эрүүл мэндийн салбар							

39	4.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.1.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг чанаржуулна.	Үйлчилгээний чанар сайжирна	100 хувь	ОНТ	Өрхийн эрүүл мэндийн төв нь 11 сарын байдлаар нийт 23086 хүнд үзлэг оношилгоо хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт-21119 иргэнийг хамруулсан байна.	100	
40			4.1.2.Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх бодлого баримтлана.	Эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй болно.	100 хувь	ОНТ	Артерийн даралт, чихрийн шижин өвчний үзлэгт 3334 иргэн хамрагдахаас 3145 иргэн хамрагдаж 94,3%, Хөхний өмөнгийн үзлэгт 3580 иргэн хамрагдахаас 2491 иргэн хамрагдаж 69,5%, Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт 818 иргэн хамрагдахаас 485 хүн хамрагдаж 59,2 %тай байна Товлолын дархлаажуулалтын хамралт 99.8%-тай явагдлаа.	100	
41			4.1.3 Хөдөөгийн багийн иргэдэд эрүүл мэндийн цогц үйлчилгээг хүргэнэ.	Жилд 2 удаа	100 хувь	ОНТ	Хөдөөгийн багуудад нийт 8 удаагийн үзлэгээр 531 иргэнд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, 266 айл өрхүүдээр орж Тэмбүү илрүүлэх шинжилгээнд-266 хүн В,С вирусн илрүүлэг шинжилгээнд-47 0-5 насны хүүхэд-37 Товлолын дархлаажуулалтанд-20 хүүхэд Томуугийн дархлаажуулалтанд жирэмсэн-8, ахмад-10, 3-5 настай хүүхдэд-14 нийт 32 иргэн хамруулсан. А витамин-10 хүүхдэд Хөхний өмөнгийн үзлэгт-42 4 хүнд яаралтай тусламж үзүүлэн 229500 төгрөгийн эм тариагаар үйлчилсэн.ӨЭМТөв автомашинтай болсноор хөдөөгийн багуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, нярай болон ахмад настны гэрийн эргэлт, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг үзүүлдэг болсон.	100	
42			4.1.4.Хувийн эмнэлэг, сувилал байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	Хувийн эмнэлэг, сувилал байгуулах санал			ХХО	“Дорнын оточ” уламжлалт эмчилгээний хувийн эмнэлэг нь 3 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. ХХҮГ-тай хамтран ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй 16 иргэнд уламжлалтын бариа засал сэргээн засах үйлчилгээг үзүүлсэн. Мөн хэвтрийн 10 өвчтөнд уламжлалтын цогц үйлчилгээг үзүүллээ “Гэгээн мандарваа” ХХК нь .10 дугаар сараас уламжлалт бариа заслийн 30 төрлийн багц үйлчилгээг 210 хүнд үзүүлсэн байна.	100
43			4.1.5 ӨЭМТ-д эх нярайн нэг удаагийн цомог авч өгнө.	Нялхсын эндэгдлийн суурь түвшин өмнөх		100 хувь	ОНТ	Жирэмсний хяналтад 251 эмэгтэйг авч жирэмсний эрт үеийн хяналт 82.8%-тай байна.	100


				оноос буурсан байна.			270 нярай шинээр мэндэлсэн. Нийт 0-5 насны 1388 хүүхэд гэрээр эргэлт хийж анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Хөдөөгийн багуудад 5 удаагийн үзлэг хийж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Нярайн гэрийн эргэлтийг тогтмол хийж байна.	
44			4.1.6 ӨЭМТ-ийг суудлын машинаар хангана.	Авто машины тоо 1 ш	Гүйцэтгэлээр	Сумын ОНХС	ӨЭМТ-д сумын орон нутаг хөгжил сангийн 20 сая төгрөгөөр "Сүмбэр зууч" ХХК-тай гэрээ байгуулан "Toyota vish" маркын автомашин авч өгсөнөөр хөдөөгийн багийн иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлэх боломж нөхцлийг бүрдүүлж өгсөн.	100
4.2. Боловсрол, соёл урлаг, спортын салбар								
45	4.2	Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулна.	4.2.1.Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг шинээр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	Газрын бодлогоор дэмжсэн хувийн сургууль, цэцэрлэгийн тоо		ХХО	Суманд хувийн хэвшлийн 5 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд шинээр сургууль, цэцэрлэг байгуулах санал ирээгүй байна.	100
46			4.2.2.Сургуулиудын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, сургалтын материаллаг баазыг үе шаттай өргөжүүлнэ.	Хүүхдийн суралцах орчин сайжирна.	100 хувь	УТХО ОНТ	ДЗОУБ-ын санхүүжилтээр 6 цэцэрлэгийн нүүдлийн бүлэгт 13 сая төгрөгийн тохижилт бүхий 2 гэр, мөн 100 хүүхдийн зөөлөн эдлэлийг нийлүүлсэн. Боловсролын байгууллагуудад шаардлагатай 8 компьютер, 11 принтерийг хүлээлгэн өгсөн. 2 дугаар сургуульд байгалийн ухааны кабинетыг хүлээлгэн өгсөн. 6 дугаар цэцэрлэгийн гадна хашааны тохижилтын ажил, 5 дугаар сургуулийн заалны шалны засварын ажлыг хийж гүйцэтгэсэн	100
47			4.2.3 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн байрыг барьж ашиглалтанд оруулна.	СӨБ-ын хамрагдалт нэмэгдэнэ.	100 хувь	ХО	5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг Вритас глобал ХХК 30%-тай гүйцэтгэж байна. 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн барилгын өргөтгөлийн ажлыг Улсын төсвийн 1,508.0 сая төгрөгөөр Түмэн-Алт ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээд байна.	70
48			4.2.4 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтийн ажлыг хийнэ.	Хүүхдийн суралцах орчин сайжирна.	100 хувь	УТХО	1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтыг Улсын төсвийн 249,9 сая төгрөгөөр "Осо констракшн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
49			4.1.5 6 дугаар цэцэрлэгийн гадна хашааг шинээр барина.	Хүүхдийн суралцах орчин сайжирна.	100 хувь	ОНХС	6-р цэцэрлэгийг хашаажуулах ажлыг сумын ОНХСангийн 32.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Оч хийц" ХХК гүйцэтгэж , ажлын хэсэг хүлээж авсан.	100
50			4.2.6.Соёл урлаг,спортыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр	Төлөвлөгөө хэрэгжсэн байна	100 хувь	ОНХС	Соёл урлаг спорт нийгмийн салбаруудад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд	100

